



СОЁМБО

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

МЭДЭЭ

№181 /391/

2022.10.10

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

Сурвалжилга

ГЭРЭЛТЭЙ АМЬДРАЛЫН ЭХЛЭЛ ГЭРЭЭТ ЦЭРЭГ

Тусгай хүчний цэргийн командлал шинээр байгуулагдаж бие даан үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш анх удаа 2022-2023 оны сургуулийн жилийн сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу харьяа ангиудтайгаа хамтран 120 гаруй хугацаат цэргийн алба хаагчийг цэргийн гэрээт албанд бүртгэж, цэргийн анхан шатны боловсрол олгох сургалтыг зохион байгуулж байна.

Эх орны дөрвөн зүг найман зовхисоос 2021 оны нэг, хоёрдугаар ээлжээр хугацаат цэргийн албанд татагдсан залуус дундаас өөрийн хүсэл сонирхлын дагуу цэргийн гэрээт албанд хамрагдаж байгаа юм.

Гэрээний дагуу хоёр жилийн хугацаанд үүргээ амжилттай гүйцэтгэсэн алба хаагчид ахлагчийн бүрэлдэхүүнд шилжих, их дээд сургуульд суралцах боломжтой. Мөн гэрээгээр ажиллах хугацаандаа НҮБ-ын Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх бүрэн боломжтой аж.

Цэргийн хүн болох чин хүсэлтэй, өөрийгөө хөгжүүлж гэсэн гал цогтой залуусаар Зэвсэгт хүчний Тусгай хүчний цэрэг хүрээгээ тэлж байна. Цэргийн гэрээт албанд улирагсдын дунд спортын нэг, хоёрдугаар зэрэг, мастер цолтой, гадаад хэлний мэдлэгтэй, цахилгаанчин, хүнд машин механизмын жолооч, барилгын инженер, компьютерын программист зэрэг мэргэжилтэй залуус байгаа бөгөөд Зэвсэгт хүчинд нэн шаардлагатай тусгай мэргэжлийн хүний нөөцийг бүрдүүлж байгаа юм.



ЗЭВСЭГТ ХҮЧИНД МЭРГЭШСЭН ЦЭРГҮҮДИЙГ БЭЛТГЭЖ БАЙНА

ЧАДВАРЛАГ ЗАЛУУСААР ХҮЧЭЭ ЗУЗААТГАЖ БАЙНА



ТХЦК-ын Цацраг, хими биологи радиациас хамгаалахын офицер дэд хурандаа Х.БАТЗОРИГ:

-ТХЦК-ын 2022-2023 оны сургуулийн ажлын төлөвлөгөөний дагуу Зэвсэгт хүчний 14 ангиас өөрийн хүсэл зорилгоор ТХЦК-ын харьяа ангиудад цэргийн гэрээт албанд 120 гаруй алба хаагч татагдан ажлын байрны анхан шатны сургалтад хамрагдаж байна. Сургалт Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн байрлалд, 8 цагаар

14 өдрийн турш явагдах юм. ТХЦК-ын харьяа ангиудаас томилогдсон шилдэг офицерын бүрэлдэхүүн сургагч багшаар ажиллаж байна. Тусгай хүчний анхны цэргийн гэрээт алба хаагчдын сургалтын удирдагчаар ажиллаж байгаагаараа бахархаж байна. Цаашид мэдлэг боловсролтой, олон төрөл мэргэжлийн залуусаар гэрээтний алба маань цуваа татна гэдэгт итгэлтэй байна. Гэрээт цэрэг бол гэрэлтэй алба юм шүү.

ТУСГАЙ ХҮЧНИЙ ЦЭРЭГ БАЙНА ГЭДЭГ НЭР ТӨРИЙН ХЭРЭГ



Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн тасгийн захирагч, ахлах ахлагч Д.ЭРДЭНЭЧИНГИС:

-Тусгай хүчний цэргийн командлалаас санаачилсан хөтөлбөрийн дагуу Тусгай хүчний цэргийн гэрээт албанд элсэх хүсэлт гаргасан хуацаат цэргийн алба хаагчдын сургалтад салааны захирагч, сургагч багшаар ажиллаж байна.

Уг сургалт маань цэргийн гэрээт алба хаагчдыг анги салбартаа хувирлагдан

очихоос өмнөх ажлын байрны анхан шатны мэдлэг олгох зорилготой юм. Өөрсдийн хүсэл сонирхлоор хугацаат цэргийн албанаас шилжин суралцаж байгаа болохоор зааж буй хичээл сургууль дадлагад маш идэвхтэй хамрагдаж, чадварлаг баг хамт олон болж байна.

ТХЦК-ын анхны гэрээт цэргүүдийг бэлдэж буй минь нэр төрийн хэрэг. Цэргийн суурь мэдлэг олгох онолын болон дадлагын хичээлүүд орж байгаа бөгөөд алба хаагчдын сурах идэвх, тусгай хүчний цэрэг болж байна гэсэн догдлол, хүлээлт өндөр байгаа нь харагдаж байна.

Албандаа манлайлсан шилдэг хүний нөөц бий болгохын төлөө энэ сургалтын хугацаанд сургагч багшийн бүрэлдэхүүн хичээх болно.

Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн мото буудлагын ротын захирагч ахмад Г.ГАНСҮХ:

-Би ҮБХИС-ийн ЦКС-ийг 2014 онд ерөнхий цэргийн командын офицер мэргэжлээр төгссөн. Одоо Тусгай хүчний цэргийн гэрээт алба хаагчдын ажлын байрны анхан шатны сургалтад ротын захирагчаар ажиллаж байна.

Манай ротод Зэвсэгт хүчний 14 нэгтгэл, ангид хугацаат цэргийн алба хаасан цэргийн гэрээт алба хаагчид хамрагдаж байна. Мөн олон улсын спортын мастер, англи, герман, турк хэлтэй залуус олон байгаа бөгөөд ахлагчийн албанд шилжих, цаашлаад офицер, англи хэл сураад рейнжер болох хүсэл тэмүүлэлтэй суралцаж байна.

Түүнчлэн энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж дэлхийд нэрээ гаргах, Зэвсэгт хүчний уралдаан тэмцээнд орж томилогдсон анги байгууллагынхаа нэрийг өндөрт өргөнө гэсэн чин хүсэл эрмэлзэлтэй залуус байгаа нь ажиллахад урамтай байдаг. Бид



Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн салааны захирагч, дэслэгч Б.ӨСӨХБАЯР:

-Тусгай хүчний цэргийн гэрээт алба хаагчдын сургалтын явц дунд шатандаа шилжиж байна. Цэргийн алба хаагчийн мэдлэг, байнгын бэлтгэл сургуулилт, ямар ч сорилтод бэлэн байх чадвар бол улс орныг батлан хамгаалах үндсийн үндэс юм.

ЦЭРГИЙН АЛБА ХААГЧ ЯМАР Ч СОРИЛТОД БЭЛЭН БАЙХ ЁСТОЙ



Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн салааны захирагч, дэслэгч Б.ӨСӨХБАЯР:

-Тусгай хүчний цэргийн гэрээт алба хаагчдын сургалтын явц дунд шатандаа шилжиж байна. Цэргийн алба хаагчийн мэдлэг, байнгын бэлтгэл сургуулилт, ямар ч сорилтод бэлэн байх чадвар бол улс орныг батлан хамгаалах үндсийн үндэс юм.

Энэ зарчмыг баримталж сургагч багшийн үүргээ гүйцэтгэж байна. Цэргийн гэрээт алба хаагчид маань өөрсдийн хүсэлтээр ирж байгаа учир сургалт бэлтгэлдээ илүү идэвх чармайлттай, заасан зүйлийг хурдан ойлгож, албандаа хурдан дасаж байгаа.

Цэргийн гэрээт албыг их дээд сургууль төгссөн, хятад, англи, турк хэлний мэдлэгтэй, боловсролтой цэргийн алба хаагчид сонгон ирж байгаа нь сайшаалтай хэрэг бөгөөд тусгай хүчний цэргийн ангиуд мэдлэг чадвар өндөр, бие бялдрын өв тэгш хөгжилтэй, спортлог, цэргийн хэргийн мэдлэг ур чадвартай хүний нөөцөөр хүрээгээ тэлж байгаад баяртай байна.

Цэргийн гэрээт албыг сонгосон нийт түрүүч нартаа сургалтаа амжилттай дүүргээд өөрсдийн мэдлэг чадвараа дайчлан, тулгарсан бэрхшээл саадыг шантралгүй даван туулж, өргөсөн тангарагтаа үнэнчээр зүтгэхийг хүсье. Тусгай хүчний цэргийн командлалын нэр хүндийг өндөрт өргөж яваарай залуус минь!

ЦАГ АГААР

УЛААНБААТАР	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 13	☁️ -3

ӨМНӨД СУДАН	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 32	☁️ 23

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.460.00	3.480.0
EUR 🇪🇺	3.420.0	3.450.0
CNY 🇨🇳	484	487
RUB 🇷🇺	53.60	54.20
JPY 🇯🇵	24.20	24.60
KRW 🇰🇷	2.46	2.50

ЗУРХАЙ

2022.10.10 /ДАВАА ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 16

НАМРЫН ДУНД САРЫН ШАРАГЧИН ТАХИА САР НАЙМАН ЦАГААН МЭНГЭТЭЙ УЛААН БИЧ ӨДӨР

Үс засуулбал:
Өвчин ирнэ
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
07.04-18.15
Барилдлага:
Рашаан
ШҮТЭН БАРИЛДЛАГА:
Авахуй

Тухайн өдөр нохой, хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Эл өдөр насны хүч дэлгэрнэ. Эм найруулах, угаал үйлдэх, бэр авах, насны авшиг, насны бүтээл хийх зан үйл хийгээд төрөл садан бололцох, худалдаа наймааны үйлнээ сайн болой, эм найруулах, гэргий авах, үс авах, элч зарах, эд авахад сайн. Зүүн нүд татвал хэрүүл, тэмцэл болох, баруун нь бол эд хувцас олох, зүүн чих нь цангинавал зочин ирэх, баруун нь бол гаслан болох, нохой уливал галзуурах, хэрээ гуаглавал ураг садан эндэх, тагнай загатнавал хэн нэгний үхсэнийг сонсох, бие татвал гэнэт зочин ирэх, хөл татвал үхэл болохыг үзэх болой.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол
Нийт: 626,625,144

Эдгэрсэн
Нийт: 606,235,525

Нас барсан
Нийт: 6,560,908

Цаг үе, үйл явдал

ЦЭРГИЙН ТАКТИК БОЛ СОНГОДОГ АРГА
УХААН ЮМ

Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн салааны захирагч, дэслэгч Б.ШИЖИРБУЯН:

-Би цэргийн гэрээт алба хаагчдын ажлын байрны анхан шатны суралтад Дархан-Уул аймгаас сургагч багшаар томилогдон ажиллаж байна. Тусгай хүчний ангиудад өөрсдийн хүсэл сонирхлоор болон цаашид мэргэжлийн ахлагч болох зорилготой залуус уг суралтад маань хамрагдаж байгаагаараа онцлог юм.

Миний бие цэргийн гэрээт алба хаагчдад ерөнхий тактик хичээлийг зааж байна. Өөрсдийн хүсэл сонирхлоороо нэгдсэн залууст хичээл орж байгаадаа маш их баяртай, бахархалтай байна. "Энхийн цагт хөлс их асгавал дайны цагт цус бага урсана" гэдэг зарчмыг



цэргүүддээ захиж, албандаа баримтлахыг сургадаг. Хичээлдээ идэвх санаачилгатай, сурья мэдье гэсэн туйлын хүсэлтэй залууст өөрийн мэддэг чаддаг бүхнээ заахыг хичээж байна.

ЖАГСААЛЫН БЭЛТГЭЛ ЖАВХААТАЙ БАЙНА

Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн миномётны батареены салааны захирагч дэслэгч Ч.ТӨГӨЛДӨР:

- Энэ жил маш онцгой жил болж байна. Тусгай хүчний командлал анх удаа цэргийн гэрээт алба хаагчдыг олноор элсүүлж түрүүч цол олголоо.

Цэргийн гэрээт алба хаагчдад сурч мэдэх зүйл их байгаа тийм ч учраас цэргүүд маань хүсэл тэмүүлэл дүүрэн эрдэм номдоо шамдан боловсорч бие бялдар болон сэтгэл зүйн өөрчлөлтийг өөртөө хийж, өдрөөс өдөрт улам илүү чадваржин суралцаж байгаад салааны захирагчийн хувьд баяртай байна. Миний хувьд жагсаалын хичээл орж байна. Хугацаат цэргийн

албанаас татагдаж ирсэн залуус учир жагсаалын бэлтгэл жавхаатай сайн байна. Гэхдээ энэ бол цэргийн гэрээт алба учир илүү үлгэр жишээч, мэргэшсэн байх ёстой гэсэн үүрэг өгч ажиллаж байна.

Тухайн улс орны тусгаар тогтнол, түүнийг батлан хамгаалах цэрэг, армийн хүчин чадлыг харуулдаг зүйлийн нэг яах аргагүй цэргийн жагсаал юм.

Хугацаат цэргийн алба амжилттай хааж, тусгай хүчинд үргэлжлүүлэн цэргийн гэрээт алба хаагч болж ажиллахаар зориг хүсэл шулуудсан шилдэг манлайлагч цэргийн алба хаагчдаа баяр хүргэе.



ААВ ШИГЭЭ ЦЭРГИЙН ДАРГА БОЛОХЫГ МӨРӨӨДДӨГ

Түрүүч Э.ПҮРЭВБАТ:

-Би хугацаат цэргийн албаа 2021-2022 онд Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн харуул үйлчилгээний тустай ротод хаасан. Албаа хааж байх явцдаа цэргийн гэрээт албыг их сонирхож том боломж гэж харсан. Би хүнд машин механизмын оператор мэргэжилтэй. Гэхдээ цэргийн гэрээт албанд хоёр жилийн хугацаатай ажиллаад, тэр хугацаандаа энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж, өөрийгөө тал бүрээр хөгжүүлж, ҮБХИС-д суралцаж офицер болох

зорилготой. Миний аав цэргийн хүн. Багадаа ааваасаа үлгэр дуурайл авч өссөн, том болоод яг аав шигээ хүн болно гэж их мөрөөддөг байсан. Одоо л цаг нь ирлээ гэж өөрийгөө зоригжуулан, мөрөөдлөө биелүүлэх гэж цэргийн гэрээт албанд элссэн. Аливааг багаас нь эхлэх сайхан шүү дээ. Мөр зэрэгцэн суралцаж буй залуустаа, чаддаг бүхнээ зааж буй эрдэмтэн багш нартаа болон Тусгай хүчний цэргийн командлалын хамт олондоо баярлалаа. Монгол Улсын төлөө зүтгэе.



ЦЭРГИЙН ГЭРЭЭТ АЛБА ХААХ БОЛСОНДОО
БАЯРТАЙ БАЙНА

Түрүүч Б.ДОРЖБАТ:

-Би Ховд аймгийн Мянгад сумаас Зэвсэгт хүчний 340 дүгээр ангид хугацаат цэргийн албанд татагдан дэд түрүүч цолтой алба хааж байх үед Зэвсэгт хүчний 331 дүгээр ангиас цэргийн гэрээт албанд элсүүлэх тухай мэдээ ирсэн юм.

Өөрийн мөрөөдөл сонирхлын дагуу цэргийн гэрээт албанд ажиллах хүсэлт гаргаж улмаар цэргийн хэргийн анхан шатны мэдлэг олгох сургалтад хамрагдаж байгаадаа сэтгэл өндөр байна. Би хугацаат цэргийн албанд татагдахаасаа өмнө "Ховд" их сургуулийн барилгын инженерийн ангид суралцаж байсан.

Их сургуулиасаа чөлөө авч хугацаат цэргийн албанд мордож байлаа. Цэргийн амьдрал их таалагдаж, салааны захирагч нар шигээ цэрэг удирдаж, хичээл заадаг дарга болох юмсан гэсэн мөрөөдөлд хөтлөгдөн цэргийн гэрээт албыг сонгосон.

Сургалтаа дуусаад томилогдож очих Зэвсэгт хүчний 331 дүгээр анги нь буудлага, уулын авиралт зэрэг сургалт бэлтгэлийг түлхүү явуулдаг, уралдаан тэмцээнд манлайлдаг нь их таалагдсан. Цаашдаа хоёр жилийн хугацаанд өөрийгөө дайчилж, сурч хөгжиж, хичээл зүтгэл гарган ажиллаж ҮБХИС-д сурах зорилготой байгаа.

Х.УНДАРМАА



ШИЛДЭГ ТҮРҮҮЧ, БАЙЛДАГЧ НАР ШАЛГАРЛАА



Зэвсэгт хүчин, Хилийн цэрэг, Дотоодын цэргийн шилдэг хугацаат цэргийн алба хаагчдын дунд зохиогдсон "Цэргийн мэргэжлийн аварга түрүүч, байлдагч" шалгаруулах тэмцээнд 10 дугаар сарын 7-ны өдөр Хужирбулан дахь Сургалтын төвд амжилттай явагдлаа.

Тэмцээнд 20 гаруй байгууллагын 40 гаруй хугацаат албаны дайчид цэргийн хэргийн онолын мэдлэг, биеийн тамирын бэлтгэлжилтийн түвшин, нормативын бэлтгэл, буудлага зэрэг 8 төрлөөр өрсөлдөж, түрүүч, байлдагч тус бүрдээ аваргаа тодруулав. Тэмцээний хаалтын

ёслолд Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч, бригадын генерал Ч.Цогтжаргал тэргүүтэй Зэвсэгт хүчин, Хилийн цэрэг, Дотоодын цэргийн штабын удирдлагууд оролцож, хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдөж, шилдэг дайчдын шагналыг гардуулан баяр хүргэсэн юм.

"Цэргийн мэргэжлийн аварга түрүүч"-ийн төрөлд тэргүүн байрт дэд түрүүч Б.Гантөгс /326/, дэд байрт, дэд түрүүч О.Батболд /016/, гутгаар байрт түрүүч Э.Төгөлдөр /339/ нар шалгарлаа.

"Цэргийн мэргэжлийн аварга байлдагч"-ийн төрөлд тэргүүн байрт байлдагч

Т.Баянмөнх /327/, дэд байрт ахлах байлдагч Ц.Цогтсайхан /119/, гутгаар байрт Хил хамгаалах байгууллагын байлдагч Э.Алтан-Эрдэнэ нар тодорч, өргөмжлөл, медаль, үнэ бүхий зүйлээр шагнагдлаа.

Мөн буудлага, биеийн тамир, бусад нормативуудыг амжилттай гүйцэтгэсэн хугацаат цэргийн алба хаагчдыг "Онц буудлагч", "Тамирчин дайчин", "Онц сурлагатан" медалиар шагнаж, урамшуулав.

Шагнагдсан дайчдад хандаж бригадын генерал Ч.Цогтжаргал "Эрхэм дайчдынхаа энэ өдрийн амар амгаланг айлтгая. Цэргийн хүний ёсоор байгаль цаг уурын

хүндрэлтэй нөхцөлд өгөгдсөн даалгаврыг амжилттай гүйцэтгэж, тэмцээндээ амжилттай оролцсон түрүүч, байлдагч нартаа баяр хүргэе.

Монгол Улсын газар нутаг уудам, хүн ам цөөхөн. Уудам эх орноо хамгаалах нь 18 нас хүрсэн эр хүн бүрийн үүрэг билээ. Энэ үүргээ нэр төртэй гүйцэтгэсэн та бүхнээрээ Зэвсэгт хүчин, орон нутгийн зон олон, ахан дүүс, ард түмнээрээ бахархан бахдаж байна. Та бүхэн эх орныхоо хамгийн эрхэм дайчид бөгөөд удахгүй халагдахаар бэлтгэл үүрэгтнүүд болно.

Цэргийн алба хаасан болон хаагаагүй залуус их ялгаатай. Хандлага харилцаа,

сэтгэлгээ, бие даах чадвар, төлөвлөлт зохион байгуулалт, тэсвэр хатуужил, нөхөрлөл, итгэл даах байдал гээд олон зүйлээрээ ялгарч, торойж харагддаг. Ард түмэн ч ингэж дүгнэж, үнэлдэг. Мэдээж тэмцээн учраас нэг хэсэг нь түрүүлнэ.

Гэхдээ тэмцээнд оролцсон та бүхэн бүгдээрээ ялагч, эх орноо батлан хамгаалах үүргээ биелүүлснээрээ ч бүр том ялагч. Тамирчин дайчдаа бэлтгэн оролцуулсан Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиуд, Хилийн цэрэг болон Дотоодын цэргийн штабын удирдлагад гүн талархал илэрхийлье" гэсэн юм.

АХМАД М.МӨНХЗОРИГ

ДАЙНД ОРОЛЦСОН АХМАД ДАЙЧДАД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭВ



Ардын хувьсгалын болон Зэвсэгт хүчний 101 жилийн ой, Халхын голын байлдааны ялалтын 83, Чөлөөлөх дайны ялалтын 77 жилийн ой, Олон улсын Ахмадын өдрийг тохиолдуулан Зэвсэгт хүчний Жанжин штаб, Дайнд оролцогчдын Монголын хороо, "Эх орны дайчид" ТББ хамтран 1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны Чөлөөлөх дайн, 1947-1948 оны Баруун хилийн тулгаралтад оролцсон ахмад дайчдад хүндэтгэл үзүүлэх ёслолын ажиллагааг энэ сарын 7, 8-ны өдөр зохион байгууллаа.

Энэ үеэр ЗХЖШ-ын Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийн аялгуун дор дайнд оролцсон морьт дивизийн Байлдааны туганд ахмад

дайчид маань хүндэтгэл үзүүлж, адис авсны дараа ахмад дайчдын алдар гавьяаг алдаршуулж, ЦДБЭЧ-ын уран бүтээлчид ая дуугаа өргөлөө. Энэхүү үйл ажиллагаанд Дайнд оролцогчдын Монголын хорооны тэргүүн бэлтгэл хурандаа Г.Лүндэн, "Эх орны дайчид" ТББ-ын тэргүүн



Р.Баяр, ЗХЖШ-ын Сургалт бэлтгэлийн газрын Суртал хүмүүжил, сэтгэл зүйн хэлтсийн мэргэжилтнүүд, "Сүү" ХК-ны ажилтнууд болон ахмад дайчдын гэр бүл, үр хүүхдүүд, төрөл төрөгсөд, иргэд, залуучууд, өсвөр үеийнхний төлөөлөл оролцсон юм.

Дайнд оролцсон ахмад дайчид та бүхэндээ эрүүл энх байж, урд удаан наслахын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлж. Ахмад дайчдын алдар гавьяа үүрд мөнх!

ДЭСЛЭГЧ Т.ИДЭР

МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ
№01

Монгол бичгийн хичээл №01

Монгол бичиг бол:

1. Босоо хэлбэртэйгээрээ
 2. Эртний монгол хэлийг тусгаснаараа
 3. Өнөөг хүртэл орхигдож мартагдаагүйгээрээ онцлог.
- Монгол бичгээ сурах хүн юуны өмнө дараах хэдэн зурлагыг нүдлэн тогтоодог. Эдгээр нь монгол бичгийн үсэг бүрдүүлэгч үндсэн махбод юм.

1. ТИТЭМ

Үсгийн эхэнд ордог. Уншигч та бүхэн дөрвөлжин шугамтай дэвтэр дээр үзгэн бал буюу балын харандаагаар титэм зурлагыг 45 хэмийн налуутай, үзгээ салгалгүйгээр, олон удаа бичээрэй.

Дармалаар:

Бичмэлээр:

